

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ХОРООНЫ ОРОН НУТАГ ДАХЬ ТӨЛӨӨЛӨГЧДИЙН 2014 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛ

2014.11.10

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

Хорооны орон нутаг дахь төлөөлөгчдийн 2014 оны эхний хагас жилийн ажлын тайланг нийт 21 аймаг, 1 нийслэл, 9 дүүргээс төлөөлөгч ирүүлэхээс 17 аймаг, 7 дүүргийн 24 төлөөлөгч буюу 77,4 хувь нь ажлын тайлангаа ирүүллээ. 4 аймаг, 5 дүүргийн төлөөлөгчид хугацаа хожимдуулсан бөгөөд Баянхонгор, Увс, Хөвсгөл, Сэлэнгэ аймаг болон Нийслэл, Сонгинохайрхан, Багануур дүүргийн төлөөлөгчид тайлан огт ирүүлээгүй байна.

Хорооны зохицуулалтын хүрээнд хамрагдан орон нутагт үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын ажлыг шалгах, холбогдох хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, санхүүгийн зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудаас үзүүлэх үйлчилгээг сайжруулах, хууль тогтоомжийг сурталчлан ажиллах эрх үүргүүдийг хэрэгжүүлэхээр эхний хагас жилд Хорооны орон нутаг дахь төлөөлөгчид дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Хоёр. Хөрөнгийн зах зээлийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, сурталчлах, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр: Хорооноос хүргүүлсэн чиглэлийн дагуу хувьцаат компаниудын санхүүгийн тайланг хянаж, аудитаар баталгаажуулсан нийт 89 хувьцаат компанийн жилийн эцсийн тайланг Өвөрхангай, Архангай, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Дундговь, Дорнод, Дорноговь, Завхан, Хэнтий, Хөвсгөл, Төв, Сүхбаатар, Өмнөговь, Орхон, Говьсүмбэр аймгуудын төлөөлөгчид Хороонд ирүүлжээ.

Дархан-Уул аймгийн төлөөлөгч Санхүүгийн тайлангаа хоцроосон 2 хувьцаат компанид Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу торгууль ноогдуулан ажилласан. Өвөрхангай аймгийн төлөөлөгч 2013 оноос Нягтлан бодох бүртгэлийн E-BALANCE програм, тайлангийн улирал, жилийн “А”, “Б” маягтууд шинэчлэгдсэнтэй холбогдуулан Санхүүгийн төрийн сангийн хэлтсийн ажлын төлөвлөгөөнд бүх сумдад ажиллах график гарган, Хувьцаат компаниудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхээр тусгуулан ажилласан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах, хурлын тэмдэглэл, хувьцаа эзэмшигчдийн хурлыг олон нийтэд мэдээлэх, ногдол ашиг тараах, хяналт тавих ажлуудыг Баян-Өлгий, Булган, Дундговь, Дорнод, Хэнтийн аймаг дахь төлөөлөгчид зохион байгуулж, хувьцаат компаниудын холбогдох материалыг Хороонд ирүүлжээ.

Дорнод, Дорноговь аймаг дахь төлөөлөгчид тус аймагт үйл ажиллагаа явуулж байгаа брокер, дилерийн компаниудын салбартай хамтран Хөрөнгийн зах зээлийн талаарх мэдээлэл,

анхан шатны ойлголтыг иргэдэд өгч, сургалт зохион байгуулж ажилласан бөгөөд мөн мэдээллийн ил тод байдлыг хангах, иргэдийн санхүүгийн боловсролд анхааран орон нутгийн телевизүүдэд хөрөнгийн зах зээл, үнэт цаас, хувьцаатай холбоотой мэдээлэл өгч, аймгийн ард иргэдэд сурталчлан ажиллажээ.

Завхан аймаг дахь төлөөлөгч хувьцаат компаниудын үйл ажиллагааг ард иргэдэд нээлттэй ил тод болгох зорилгоор байгууллага болгон вэб сайттай болгох талаар албан бичиг хүргүүлэн, Говь-Алтай, Дорноговь, Дорнод аймгуудын брокер, дилерийн компанийн салбарууд данс нээх, арилжаанд зуучлах, худалдах, худалдан авахад зуучлах болон мэдээлэл зөвлөгөө өгөх үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

Дорнод аймаг дахь төлөөлөгч Хорооны Үнэт цаасны газрын дарга, хянан шалгагч нартай хамтран газар дээрх шалгалт хийж, 5 хувьцаат компанийн үйл ажиллагааны явц байдал, Компанийн тухай хуулиар хүлээн үүргийн хэрэгжилтийн талаар танилцаж, гарын авлага, материалаар ханган, шаардлагатай мэдээлэл солилцон, заавар зөвлөгөө өгч ажилласан бөгөөд Дархан-Уул, Завхан аймаг дахь төлөөлөгчид Хорооноос хүргүүлсэн удирдамжийн дагуу брокер, дилерийн компаниудад үзлэг хийж, шалгалтын дүнг Хороонд ирүүлсэн.

Өвөрхангай, Өмнөговь аймаг дахь төлөөлөгчид бүртгэлтэй компаниудын судалгааг шинэчлэн гаргаж, тэдгээрийн хувийн хэрэгт баяжилт хийн, судалгаа мэдээлэл гарган ажилласан, Булган аймаг дахь төлөөлөгч брокер дилерийн компанийн хаяг байршил, арилжаа нь зогссон компани болон хувьцааны талаарх мэдээллийг олон нийтэд мэдээлсэн, Дундговь, Баян-Өлгий, Ховд аймгийн төлөөлөгчид хувьцаат компаниуд ноогдол ашиг тараадаггүй, жижиг хувьцаа эзэмшигчдийг хуралд хамруулдаггүй, хэдэн том хувь эзэмшигчдийг хамруулж, хуралддаг дутагдал байгаа талаар тайландаа тус тус дурьдсан байна.

Гурав. Даатгалын салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийг хангах, сурталчлах, санхүүгийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр:

Архангай аймагт Хорооноос өгсөн чиглэлийн дагуу даатгалын зуучлагчийн эрх олгох сургалтанд банкны 46 ажилтан, Хэнтий аймагт 27 ажилтан тус тус хамрагдаж, шалгалтын материалыг Хороонд ирүүлсэн байна.

Хороо, Албан журмын даатгагчдын холбоо, Малын индексжүүлсэн даатгалын төслийн багийнхантай хамтран ажиллаж сургалт, даатгалын төлөөлчийн эрх олгох шалгалт зохион байгуулж, Баян-Өлгий аймагт 82 иргэн, Завхан аймагт 83 иргэн, Өмнөговь аймагт 80 иргэн, Өвөрхангай аймагт 101 иргэн, Төв аймагт 72 иргэн буюу даатгалын төлөөлөгчийн эрх олгох шалгалтанд нийт 418 иргэн хамрагдснаас даатгалын төлөөлөгчийн эрх олгох шалгалтанд тэнцсэн 369 иргэний материалыг Хороонд ирүүлжээ.

Баян-Өлгий, Говь-Алтай, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Төв, Ховд аймгууд болон Чингэлтэй, Хан-Уул дүүргүүдийн төлөөлөгчид

Даатгалын компанийн салбаруудын 2013 оны болон 2014 оны 1 дүгээр улирлын тайланг, даатгалын нэр төрөл бүрээр хавсралт маягтын дагуу гарган Хороонд ирүүлсэн байна.

Жолоочийн хариуцлагын даатгалын хуулийг сурталчлах, хэрэгжүүлэх үүднээс Архангай, Баян-Өлгий, Говь-Алтай, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Төв аймгуудад Даатгалын газар, Албан журмын даатгагчдын холбоо, Тээвэр, авто замын газар, Замын цагдаагийн газартай хамтран автотээврийн үзлэг, оношлогоо, татвар хураалтын талаар сургалт зохион байгуулж, цаг үеийн мэдээ, мэдээллийг Орон нутгийн мэдээллийн хэрэгслээр тусгай хуваарийн дагуу дамжуулан, аж ахуй нэгж байгууллага, иргэд даатгуулагч нарт даатгалын талаар хууль тогтоомжийг сурталчилж, сургалтын талаарх илтгэлүүд болон хууль тогтоомж, ном гарын авлагаар ханган ажиллажээ.

Хорооны Даатгалын газраас 9 аймгийн даатгалын компанийн салбарын үйл ажиллагаатай биечлэн танилцаж, үйл ажиллагаанд газар дээрх шалгалт хийж, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар тавигдах шаардлагын биелэлтийг ханган ажиллахад орон нутаг дахь төлөөлөгчидтэй хамтран ажилласан байна.

Шалгалтын явцад гол төлөв даатгалын салбаруудын хаяг өөрчлөгдөн, нөхөн төлбөр бие даан шийдвэрлэх эрхгүй, иргэдэд маш их хүндрэл учруулдаг, даатгалын компаниудын шударга бус өрсөлдөөн ихэнх аймагт гардаг байна. Тухайлбал: Баян-Өлгий аймагт Авто тээврийн улсын үзлэгийн үеэр даатгалын компанийн салбаруудын үйл ажиллагааг шалгахад, шалгалтанд орж үнэмлэх авсан төлөөлөгчид биш, менежерүүд даатгал хийж байна. Мөн оройн цагаар гэрээр нь очиж даатгал хийдэг, янз бүрийн амлалт, урамшуулал их зарладаг, татварын байцаагч болон цагдаагийн төлөөлөгчдөөр дарамтлуулж даатгуулдаг зэрэг ёс зүйгүй явдал гардгаас болж, иргэд даатгалын компаниа чөлөөтэй сонгох эрх зөрчигдөж байгаа тухай тайландаа дурджээ.

Орон нутаг дахь даатгалын компанийн салбаруудын үйл ажиллагааг сурталчлах ажлын хүрээнд Даатгалын салбар үүсч хөгжисний 80 жилийн ойг угтаж, нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл хийж, ард иргэдэд сурталчилан ажиллажээ.

Дөрөв. Бичил санхүүгийн салбарын үйл ажиллагаа холбогдох хууль, дүрэм, журамд нийцэж байгаа болон зохистой харьцааны үзүүлэлт тайланг цаг хугацаанд нь ирүүлсэн талаар:

Архангай, Баян-Өлгий, Дорноговь, Дорнод, Завхан, Дундговь, Өмнөговь, Төв, Өвөрхангай аймгуудад үйл ажиллагаа явуулж байгаа Хадгаламж зээлийн хоршоо, Банк бус санхүүгийн байгууллагуудын санхүүгийн тайлан, мэдээг батлагдсан маягт аргачлалын дагуу гаргаж, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцон, тайланг хуулийн хугацаанд багтаан Хороонд ирүүлсэн байна.

Хорооноос тусгай зөвшөөрөл аваагүй Хадгаламж зээлийн хоршоодыг орон нутгийн Улсын бүртгэлийн хэлтэс, татварын хэлтсээс тодруулах ажлыг зохион байгуулахтай холбоотой Хорооноос 7/2422 тоот албан бичгийг хүргүүлсний дагуу Булган аймагт зөвшөөрөл аваагүй үйл ажиллагаа явуулдаг хоршоо байхгүй бөгөөд 2 ХЗХ бүх гишүүдийн хурлын шийдвэрээр хоршооны үйл ажиллагаагаа зогсоож, 1 Хадгаламж зээлийн үйл ажиллагааны чиглэлээ ХХК болгон өөрчилсөн, Говь-Алтай аймагт 2 ХЗХ татан буугдсан, Өвөрхангай аймагт 4 ХЗХ улсын бүртгэлд бүртгэлгүй, татварын хэлтсийн баазаас татан буугдсан гэсэн үндэслэлээр хасагдсан бөгөөд Хорооноос тусгай зөвшөөрөл авч байгаагүй 1 ХЗХ-г хуулийн дагуу хасахыг мэдэгдсэн, Өмнөговь аймагт 1 ХЗХ татан буугдсан, Дорнод аймагт 3 ХЗХ үйл ажиллагаа явуулахгүй байгаа бөгөөд зээлийн эргэн төлөлттэй тул холбогдох журмын дагуу шүүхэд нэхэмжилсэн, Завхан аймагт тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон 42 хоршоог татан буулгуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байгаа талаар аймгууд Хороонд албан бичгээр мэдэгдсэн байна.

Булган, Дорнод аймгуудад Хадгаламж зээлийн хоршоод Хас банкттай хамтран франчайзын гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд үр дүнд хүрч, гишүүдийн тоо өсч, зээлийн багцын чанар сайжирч, үйл ажиллагаа тогтмолжиж байгаа талаар төлөөлөгчид тайланд тусгасан байна.

Дархан-Уул аймаг дахь төлөөлөгч шинээр 1 Банк бус санхүүгийн байгууллага болон салбар байгуулахаар хүсэлт ирүүлсэн 2 компанийн ажлын байр, техник тоног төхөөрөмж, боловсон хүчний судалгаа, шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа талаар үзлэг хийж Хороонд мэдээлсэн. Дорнод аймагт 2013 онд Хорооноос ирсэн газар дээрх шалгалтанд 4 ХЗХ “Маш сайн” үнэлгээтэй дүгнэгдсэн.

Өвөрхангай аймагт “Онгийн харз” ХЗХ нь бүх гишүүдийн ээлжит бус хурал хийж, хоршооны үйл ажиллагаанд мөрдөж байгаа дүрэм, журмуудаа шинэчлэн баталж, Хорооноос төслийн хүрээнд зохион байгуулсан сургалтанд 10 хүнийг хамруулж, мэдлэг чадварыг нь дээшлүүлэн, бүх гишүүдээ 21 аймагт хувааж, ахлагчийг томилж ажилласнаар үйл ажиллагаа нь идэвхижиж, хадгаламжийн сангийн хэмжээ харьцангуй нэмэгдсэн байна.

Дорнод аймагт Хорооноос ББСБ, ХЗД-ын захирал, нягтлан бодогчдод санхүүгийн тайлагналын олон улсын стандартад гарсан өөрчлөлт сэдвээр сургалт зохион байгуулсан ажиилласан байна.

Тав: Дүгнэлт

Хорооноос орон нутагт ажиллаж, хяналт, шалгалт хийж, зохицуулалттай этгээдийн бодит байдалтай танилцаж, зөрчил дутагдлыг илрүүлж, холбогдох хууль, дүрэм журам, заавар, хорооноос авч буй арга хэмжээ, цаашид хийх ажлын талаар мэдээлэл өгч, бүртгэл судалгаа гарган хамтран ажилласан бөгөөд Хорооноос зохион байгуулсан “Хүртээмжтэй даатгал-2014” олон улсын форум, Хорооны үйл ажиллагааны стратеги /2012-2016/-ийн хэрэгжилтийн хэлэлцүүлэг, Орон нутгийн төлөөлөгчдийн семинарт хамрагдаж, мэдлэг боловсролоо дээшлүүлж, цаг үеийн мэдээлэл солилцсон талаар төлөөлөгчид тайландаа дурьдсан байна.

Хорооны орон нутаг дахь төлөөлөгчид хөрөнгийн зах зээлийн талаарх мэдээлэл олж авах, үнэт цаасны арилжаанд оролцох, хувьцааны данс нээх, арилжаанд зуучлах, хувьцаат компаниудын ногдол ашиг тараалт болон брокер, дилерийн компаниуд, тэдгээрийн хаяг, байршлыг сурталчлан, тэдгээр компаниудын санхүүгийн тайланг улирал бүр хянаж, тайлангуудыг хэвлэлд нийтлүүлэн, арилжаа нь зогссон хувьцаат компаниудын мэдээллийг олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулан ажилласан. Мөн Хорооноос явуулсан чиглэлийн дагуу төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах, хурлын тэмдэглэл, санхүүгийн тайлангийн хураангуй болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг олон нийтэд мэдээлэх, ТУЗ-ийн гишүүд болон ТУЗ-ын нарийн бичгийн дарга нарыг компанийн засаглалын сургалтанд хамруулах ажлуудыг зохион байгуулж, холбогдох материалыг Хороонд ирүүлсэн.

Орон нутаг дахь даатгалын салбаруудын үйл ажиллагааг зохицуулах, сурталчлах ажлын хүрээнд Даатгалын салбар үүсч хөгжсний 80 жилийн ойг угтаж, нээлттэй хаалганы өдөрлөг хийж, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл хийж, ард иргэдэд сурталчилсан. Жолоочийн хариуцлагын даатгалын хуулийг сурталчлах, хэрэгжүүлэх үүднээс Хорооны Даатгалын газар, Албан журмын даатгагчдын холбоо, Тээвэр авто замын газар, Авто оношилгооны төв, Замын цагдаагийн газартай хамтран уулзалт зохион байгуулж, цаг үеийн мэдээ, мэдээллийг Орон нутгийн мэдээллийн хэрэгслээр тусгай хуваарийн дагуу дамжуулан, аж ахуй нэгж байгууллага, иргэд, даатгуулагч нарт даатгалын талаар хууль тогтоомжийг сурталчилж, сургалтын талаарх илтгэлүүд болон хууль тогтоомж, ном гарын авлагаар ханган ажилласан байна. Хорооны Даатгалын газраас орон нутагт сургалт зохион байгуулж, даатгалын төлөөлөгч, зуучлагчийн эрх олгох шалгалтанд иргэдийг хамруулж, дүн мэдээг гарган ажилласан.

Баян-Өлгий, Булган, Дорнод, Завхан, Өвөрхангай, Төв аймгийн төлөөлөгчид хийсэн ажлаа сайн тайлагнасан бөгөөд тайлан ирүүлсэн аймаг, дүүргийн төлөөлөгчид өмнөх оны тайлантай харьцуулахад орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа зохицуулалттай этгээдийн

тоо, бүртгэлийг дэлгэрэнгүй гаргаж ирүүлжээ. Нийслэл, дүүргийн төлөөлөгчдийн тайлан товч, өгөгдсөн удирдамжийн дагуу гүйцэд бичигдээгүй байгаа нь учир дутагдалтай байлаа.

Орон нутаг дах төлөөлөгчид бүртгэлтэй ХЗХ болон ББСБ-ын улирлын санхүүгийн тайланг Хорооноос баталсан маягт аргачлалын дагуу гаргаж, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг улирал тутам хүлээн авч, Сангийн яамны Е-балансын нэгтгэлд оруулж, жилийн аудитаар баталгаажуулж, Хорооны Бичил санхүүгийн газарт хүргүүлж ажилласан байна.

Хорооноос хүргүүлсэн чиглэлийн дагуу Улсын бүртгэлээс хасуулаагүй байсан ХЗХ-дыг татан буулгаж, зарим хоршоод нь хэлбэрээ өөрчилж, Татварын болон Улсын бүртгэлийн хэлтсээс зөрчил арилгасан тухай хариуг Бичил санхүүгийн газарт хүргүүлсэн байна.

2014 оны эхний хагас жилд Хорооны орон нутаг дахь төлөөлөгчдийн тайландаа ирүүлсэн саналыг нэгтгэвэл:

Булган аймаг:

- Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах хуулийг шинээр санаачлан гаргаж анх хувьцаа эзэмших үед байсан хөрөнгийг зах зээлийн үнийн өсөлтөөр нэмэгдүүлэн тооцож 1 ширхэг хувьцааны шинэчилсэн үнэлгээг тогтоож эзэмших хөрөнгийг баталгаажуулах.
- Хувьцаа эзэмшигчдийн хурлаа хийгээгүй, ноогдол ашиг олгоогүй, Хөрөнгийн зөрчилтэй хувьцаат компанийг татан буулгаж, өмчийг эзэмшигчдэд олгох эрхзүйн заалтыг холбогдох хуульд оруулах.
- Даатгалын компанийн орон нутаг дахь салбарыг бие даасан санхүүгийн тайлантай болгож, зөрчилтэй даатгалын компанийн салбар, Төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох заавар журам гаргах.
- Хас банктай хамтран франчайзын гэрээгээр ажиллах, ХЗХ-ны тоог нэмэгдүүлэх чиглэл барьж ажиллах.
- Орон нутаг дахь брокерийн компанийн үйл ажиллагааг тогтмолжуулж, шинээр гаргасан хувьцааг сурталчилан, үнэт цаасны зах зээлийг өргөжүүлэх.

Дархан-Уул аймаг

- Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, аж ахуй нэгжүүдэд үнэт цаасны зах зээлийн талаар мэдээлэл өгөх талаар үнэ төлбөргүй сургалт, мэдээлэл хүргэх хэрэгтэй байна. Сургалт мэдээлэл хүргэх ажил зохион байгуулсан нөхцөлд зарыг АЗДТГ-ын зардлаар хүргэх, үнэ төлбөргүй хичээлийн байр бэлтгэх бүрэн боломжтой.

Дорнод аймаг

- СЗХ-ны орон нутгийн төлөөлөгчийн ажлыг хавсран гүйцэтгэж байгаа учир дээрх бүх байгууллагуудтай байнгын хяналт тавьж, хамран ажиллах цаг хугацаа хомс, санхүүгийн дэмжлэг хүрэлцээгүйгээс шалтгаалан зарим байгууллагуудыг зөвхөн санхүүгийн тайлангийн үзүүлэлтээр л хянаж байна. Энэ тал дээр Хорооноос дэмжлэг үзүүлэхийг анхаарна уу.

Өмнөговь аймаг

- Хорооны Бичил санхүүгийн газраас хэрэгжүүлж буй төсөлд Хадгаламж зээлийн хоршоодоо хамруулах саналтай байна.

Төв аймаг

- Олон жил үйл ажиллагаа явуулахгүй байгаа, өмчлөл тодорхой бус болсон, захирал эзэд нь хаяг тодорхой биш хувьцаат компаниудын асуудлыг шийдвэрлэж өгөх.

**Орон нутаг дахь төлөөлөгчдийн тайланд тусгасан зохицуулалттай
ЭТГЭЭДИЙН ТООН МЭДЭЭ**

2014.11.10

№	Аймаг, дүүрэг	Тайлан ирүүлсэн огноо	Нийт бүртгэлтэй							Тайлбар
			ХК	БДК	Даатгалын салбар	Даатгалын зуучлагч	ББСБ	ХЗХ	ХААБ	
1	Архангай	VI/09	6	-	-	-	2	3	-	
2	Баян-Өлгий	VI/19	7	1	-	-	3	5	2	
3	Баянхонгор	-	-	-	-	-				Тайлан ирээгүй
4	Булган	VII/29	6	2	8	-	1	3	-	
5	Говь-Алтай	VII/16	2	1	7	-	-	2	-	
6	Говьсүмбэр	XI/01	-	-	-	-	-	-	-	
7	Дархан-Уул	VI/25	23	4	11	-	4	2	-	
8	Дорноговь	VIII/28	4	1	9	-	1	5	-	
9	Дорнод	VI/15	9	1	10	-	5	4	-	
10	Дундговь	VI/09	4	-	7	-	-	6	-	
11	Завхан	VII/23	5	1	9	-	1	-	1	-
12	Өвөрхангай	VI/25	9	1	10	-	1	3	-	
13	Өмнөговь	VIII/28	5	-	12	1	1	5	-	
14	Орхон	VII/01	8	3	12	-	6	13	-	
15	Увс	-	-	-	-	-	-	-	-	Тайлан ирээгүй
16	Сүхбаатар	VIII/27	2	1	10	-	1	2	-	
17	Сэлэнгэ	-	-	-	-	-	-	-	-	Тайлан ирээгүй
18	Төв	VI/30	-	6	8	-	-	4	-	
19	Ховд	VI/12	7	1	8	-	-	1	-	
20	Хөвсгөл	-	-	-	-	-	-	-	-	Тайлан ирээгүй
21	Хэнтий	VI/13	9	2	10	-	1	8	-	-.
22	Нийслэлийн засаг даргын тамгын газар	-	-	-	-	-	-	-	-	Тайлан ирээгүй
23	Баянгол	VIII/29	-	-	-	-	-	-	-	Тоон мэдээ ирээгүй
24	Баянзүрх	VIII/26	-	-	-	-	-	-	-	тоон мэдээ ирээгүй
25	Сонгинохайрхан	-	-	-	-	-	-	-	-	Тайлан ирээгүй
26	Сүхбаатар	VIII/26	-	-	-	-	-	-	-	
27	Хан-Уул	IX/01	-	-	-	-	-	-	-	
28	Чингэлтэй	VI/20	11	-	6	-	27	24	-	
29	Налайх	VII/17	4	1	3	2	2	-	-	
30	Багануур	-	-	-	-	-	-	-	-	Тайлан ирээгүй
31	Багахангай	VIII/28	-	-	-	-	1	-	-	
	Нийт	24								

